

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан хууль тогтоомжид тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1-т заасан дараах үе шатаар хийсэн болно: Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судлах;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Тодорхойлж шийдвэрлэх гэж буй асуудлын эрх зүйн зохицуулалт, мөн чанар, цар хүрээ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “...**хүүхдийн ашиг, сонирхлыг төр хамгаална**” гэж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “...**Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна**” гэж тус тус заажээ. Мөн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д Засгийн газар нь “**хүний эрх, эрх чөлөөг хамгаалах**, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” хэмээн заасан байна.

Энэ дагуу төр, засгийн зүгээс хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлэн, хэрэгжүүлж иржээ. Тухайлбал,

- Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хүний хөгжил” 2 дугаар бүлэгт хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих, аюулгүй амьдрах эрхийг хангах, тэдэнд зориулсан бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр “2.3.9.1.273

цэцэрлэг ашиглалтад оруулах; 2.3.9.2.200 шинэ сургууль ашиглалтад оруулах; 2.3.9.3.тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх; 5.8.Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ, “2.6.1.7.Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр байгуулна” хэмээн заасан.

Дээрх заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Хүүхдийн төлөө сан байгуулж, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах шаардлагатай байна.

Энэ хуулийг дагалдуулан хүүхдийн эрхийг хангахтай холбоотой харилцааг нарийвчлахаар Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зарим үндэслэл хэрэгцээг харгалзан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/339 дүгээр тушаалаар Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг гүйцэтгээд байна.

Үнэлгээний зорилго нь хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэсэн болно.

А. Хүүхдийн эрхийн талаар;

Хүүхдийн эрхийн тухай конвенцод:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) гишүүн улсууд хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах болон нийгмийн амьдралд оролцох бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангаж, улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд эн тэргүүнд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад онцгой анхаарлаа хандуулж ажиллах, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт зайлшгүй шаардлагатай болохыг Монгол Улс хүлээн зөвшөөрч үүрэг хүлээсэн байдаг.

Монгол Улс ямарваа нэгэн тайлбаргүйгээр Хүүхдийн эрхийн тухай конвенцыг бүхэлд нь хүлээн зөвшөөрч 1990 онд нэгдэн орж соёрхон баталсан орон билээ. Үүний дагуу манай улс хүүхдийн сайн сайхны төлөө эрх зүйн шинэчлэлийн таатай орчин бүрдүүлэхээр чармайж ирснийг доорх батлан хэрэгжүүлж байгаа хуулиудаас харж болно. Үүнд: Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай, Эрүүгийн хууль зэргийг нэрлэж болох юм.

Эрх зүйн шинэчлэлийн үр дүнд хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалуулах эрхийг хуулиар баталгаажуулснаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хуулиар хориглосон дэлхийн 49 дэх орон болсон байна. НҮБ-ын Хүүхдийн Сангийн судалгаагаар Монгол Улсад хүүхэд хамгаалал, хөгжлийн холбогдолтой хуулиудыг бүрэн хэрэгжүүлэхэд 22,0 тэрбум, бүр багадаа 11 тэрбум төгрөг шаардлагатай гэж дүгнэсэн байна. Монгол Улсын Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого боловсруулах, хүүхдийн эрхтэй холбоотой хууль

тогтоомжийн биелэлтийг хангах, хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй агентлагийг шинээр байгуулж, хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээнд сүүлийн 3 жилийн хугацаанд улсын төсвөөс зарцуулах мөнгөн дүнг нэмсэн байна. Жишээлбэл, 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019, 2020, 2021 онд тус бүр 8 тэрбум төгрөг батлагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор 2017-2021 онд хэрэгжүүлэх “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг баталж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Эрүүл мэндийн яамдуудад тус тус даалгасан байдаг. Тус хөтөлбөр нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 болон дээр дурдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020)-т хүүхдийн хөгжил, хамгаалал, эрүүл мэнд, боловсролын талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ба дор дурдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

➤ Хөтөлбөрийн зорилго:

Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

➤ Хөтөлбөрийн зорилт:

1. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ;
2. Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ;
3. Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ;
4. Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална;
5. Тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулна гэсэн зорилтуудын хүрээнд олон талт ажил хийгдэхээр хүлээгдэж байна.

Б. Хүүхдийн эрхийн тухай хуулийн зорилт, үндсэн зарчмын талаар;

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь хүүхдийн **эрхийг хамгаалах** чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон. Хуулийн агуулгаас дүгнэхэд уг хууль нь зөвхөн хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хэрхэн хамгаалах, түүнийг сэргээх талаар зохицуулсан байхаас гадна хүүхдийн үндсэн, суурь эрхийг хуулиар баталгаажуулж хүүхэд эрхээ эдлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь уг хуулийн зорилт байна. Тиймээс хуулийн зорилтыг өргөжүүлэх, түүний хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах гэдэг ойлголтоос өргөн хүрээтэйгээр зохицуулах, **“хүүхдийн эрхийг баталгаатай эдлүүлэх”**-д чиглэх, үүний тулд төрийн болон бусад байгууллагын ажиллагааг уялдуулах шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах, төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, ахиц дэвшил гарч байгаа ч хүүхдийн хөгжих, оролцох эрхийг хангаж, хөгжлийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүүхдийн хөгжлийг дэмжих орчин бүрдүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хэрэгцээ шаардлага тулгамдсаар байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоол, 2019 оны 01 дүгээр тогтоолоор “Хүүхдийн төлөө санг сэргээх асуудлаар хуулийн төсөл боловсруулан Засгийн газарт танилцуулах”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарт үүрэг болгосон.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д “хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив дэлхийн чанартай уралдаан тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам баталж хэрэгжүүлэх”-ийг заасан.

Засгийн газрын 2018 оны “Тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох тухай” 173 дугаар тогтоолд тив, дэлхийн чанартай тэмцээн уралдаанд амжилттай оролцсон өсвөр үеийн хүүхдэд мөнгөн шагнал олгох асуудлыг тусгасан ч хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлагийн чиглэлээр улс, олон улс, тив дэлхийн чанартай уралдаан тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох эрхзүйн болон санхүүгийн зохицуулалт байхгүй байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, бусад этгээд:

Монгол Улсад 560 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас 80 орчим хувь нь хүүхэд, хүүхдийн эрхтэй холбоотой заалт тусгажээ. Гэвч эдгээр зохицуулалт нь хүүхдийн эрхийг баталгаатай эдлүүлдэг эрх зүйн орчин, соёлыг төлөвшүүлэхгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар нийгмийн аливаа бүлэг, иргэн, аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхгүй, харин ч хүүхдийн хөгжлийг дэмжих орчин, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг бий болгоход төрийн болон бусад байгууллага, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагын хандив тусламжийг зөв төвлөрүүлж, зохистой зарцуулах эрх зүйн зохицуулалт бүрдэнэ.

Хүүхдийн дээд ашиг сонирхол ямагт аливаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын ашиг сонирхлоос дээгүүр байх Олон улсын зарчмыг удирдлага болголоо.

1.3. Асуудал үүссэн шалтгаан нөхцөл:

Монгол Улсын нийт хүн амын 36.8 хувийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд тэдний 35.0 хувь нь өсвөр насны хүүхдүүд байна. Өсвөр насны

хүүхдүүдэд чиглэсэн хөгжлийн үйлчилгээ, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин хангалтгүй байгаа нь тэднийг гэмт хэрэг зөрчил үйлдэх, гэмт хэрэгт холбогдох, гэрч хохирогч болох, цахим донтолт, цахим орчинд бэлгийн дарамт хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөд нөлөөлж байна. Тухайлбал, манай улсад сүүлийн 10 жилийн хугацаанд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 94 бүртгэгдсэний 25,0 хувийг хүүхэд эзэлж байна. Мөн хүүхэд оролцсон гэмт хэрэг 2016 онд 1165 байсан бол 2019 онд 1356 болж 16,4 хувиар, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд 2016 онд 1340 байсан бол 2019 онд 1598 болж, 19,3 хувиар тус тус өссөн байгаа нь хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил, оролцоог дэмжсэн, амьдрах ур чадвар олгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна.

2020 оны байдлаар улсын хэмжээнд 41 хүүхдийн зуслан үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээр зуслангаас 60 хувь нь барилга байгууламжийн хувьд хуучирч муудсан, 21-ээс дээш жил үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн хэмжээнд 20, орон нутгийн хэмжээнд 21 зуслан ажиллаж, улсын өмчит зуслан 12, орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн зуслан 3, төрийн өмчит 3, хувийн 25 зуслан байна. Жилдээ 70,000 гаруй хүүхэд зусланд хамрагддаг ба энэ нь зусланд хамрагдах 7-18 насны 600 мянга гаруй хүүхдийн дөнгөж 12 хувийг эзэлж байна.

Жил бүрийн улсын төсөвт батлагдаж буй хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардал нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд зарцуулагддаг тул хүүхдийн хөгжлийг дэмжиж, хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг улсын төсвөөс бүрэн шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг.

Монгол Улсын төр засаг, ард иргэдээс хүүхдийн сайн сайхны төлөө санаачлага гаргаж, асуудлыг шийдвэрлэж ирсэн түүхтэй бөгөөд энэхүү үйл хэргийг уламжлал болгон хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Анх 1972 онд МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн “Хүүхдийн төлөө төв фонд байгуулах тухай, Улаанбаатар Төмөр замын хамт олны уриалгыг дэмжих тухай” 30 дугаар тогтоолоор батлагдаж, Ардын боловсролын яам, Эрүүлийг хамгаалах яамны коллеги, МХЗЭ-ийн Төв хорооны товчооны 1973 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Хүүхдийн төлөө Фондын комисс байгуулах тухай” хамтарсан хурлын 108/177/15 дугаар шийдвэрийн дагуу А.И.Цэдэнбал Филатова даргатай Хүүхдийн төлөө фондын комиссын бүрэлдэхүүн болон комиссын дүрмийг тус тус баталсан байна.

Хүүхдийн төлөө фондын хөрөнгөөр 1975 оноос 1994 оныг хүртэлх 20 жилийн хугацаанд хүүхдийн 68 цэцэрлэг, 10 гаруй эмнэлэг, пионерын 70 гаруй зуслан, Хуримын ордон, Монголын Хүүхдийн ордон, Залуу техникчдийн ордон, Усан бассейн, Олон улсын Хүүхдийн Найрамдал зуслан, Монголын Хүүхэд асран хүмүүжүүлэх төв, Бамбарууш кафе, Хүүхдийн төв номын сан, Хүүхдийн театр, Хүүхэддэйн театр, Хүүхэд залуучуудын парк, Хүүхдийн шүдний поликлиник гэх мэт 200 гаруй бүтээн байгуулалтыг бий болгож, хүүхдийн эрх, хөгжлийг дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулсан түүхтэй билээ.

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990 оноос хойш өмч хувьчлал өрнөж, төрийн өмчийг хувьчлахад хүүхдийн нэртэй 145 барилга, байгууламж хувьчлагдсан байна. Тухайлбал, Хүүхдийн номын сан, Элдэв-Очирын нэрэмжит Хүүхдийн кино театр, Хүүхдийн театр, Бамбарууш кафе, Хүүхэд, залуучуудын театр, хүүхдийн зуны зуслангууд, Залуу техникчдийн ордон гэх мэт хүүхдийн хөгжлийг дэмжсэн томоохон барилга байгууламжийг дурдаж болно.

1996 онд батлагдсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасны дагуу 2005 онд Хүүхдийн төлөө сан нь Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн дэргэд байгуулагдахаар шийдвэрлэгдэж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.17-д хүүхдийн төлөө сантай байхаар хуульчлан, Засгийн газрын 2005 оны 40 дугаар тогтоол, 2008 оны 261 дүгээр тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн дүрэм, сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг батлан ажиллаж, байсан ч 2015 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Хүүхдийн төлөө сангийн зориулалт, зарцуулалт нь тодорхойгүй шалтгаанаар хүчингүй болсон байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлсон байх ба хуулийн 12.1.1.хүүхдийн **эрхийг хамгаалах** төрийн бодлого боловсруулах;

12.1.2. хүүхдийн **эрхийг хамгаалах** хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

12.1.3. хүүхдийг **хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах** талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

16 дугаар зүйлд хүүхдийн эрхийг хангах талаарх салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлтэй байхыг тус тус заасан.

Бид Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг дагалдуулан Хүүхдийн эрхийн тухай хуульд “16.6. Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжлийг дэмжих зориулалт бүхий Хүүхдийн төлөө сантай байна.” гэсэн заалтыг нэмэлтээр оруулахаар тус хуулинд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22.1.2-т заасны дагуу хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл шаардлагад тулгуурлан зохицуулах дараах асуудлыг тусгана. Үүнд:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.24 дүгээр заалтад Хүүхдийн төлөө санг нэмж тусгана.
2. Хуулийн 21² дугаар зүйлд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжлийг дэмжих гэсэн сангийн ерөнхий зориулалтыг заана.

3. Хуулийн 21² дугаар зүйлд сангийн хөрөнгийн эх үүсвэрийг тээврийн хэрэгслийн улсын дугаарын үнэ хаялцуулах дуудлага худалдаанаас олсон орлого, хүүхдийн сайн сайхны төлөө зохион байгуулсан соёл, урлагийн тоглолт, спортын арга хэмжээний орлогоос бүрдүүлэхээр тодорхойлно.
4. Сангийн хөрөнгийг хүүхдэд зориулсан бодит бүтээн байгуулалт, тив, дэлхийн соёл урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах гэсэн 2 чиглэлийг тодорхойлж, Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батлах заалтуудыг тус тус нэмэлтээр оруулна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛ ДЭЭР ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

Асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан аргачлалын Тав дахь хэсэгт заасан аргачлалыг баримтлаж асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудаас 5.1.7-д заасан **“хууль тогтоомжийн төсөл боловсруулах”** гэсэн хувилбарыг сонгож байна.

- *“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах* – Засгийн газрын тусгай сангийн тухай 2005 онд батлагдсан хуулийн 5.4.17-д Хүүхдийн төлөө санг, тус хуулийн 18 дугаар зүйлд Хүүхдийн төлөө сангийн зориулалт, бүрдүүлэлт, зарцуулалтын талаар тусгасан ч зориулалт, зарцуулалт нь тодорхойгүй шалтгаанаар 2015 онд дээрх заалтууд хүчингүй болсон. Иймд хүүхдийн хөгжлийн орчинг бий болгох, хөгжлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, хүүхдийн төлөө сангийн асуудалд төрөөс тодорхой зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байгаа учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.
- *Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх* – Эрхзүйн зохицуулалт зайдшгүй шаардлагатай асуудал тул зах зээлийн механизмаар өөрөө аяндаа шийдэгдэнэ гээд хүлээх боломжгүй учир энэ хувилбар тохиромжгүй.
- *Төрөөс санхүүгийн интервенц хийх* – Энэ хувилбар тохиромжгүй.
- *Төрийн бус байгууллага, хувийн хэвшилээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх* – Энэ хувилбар тохиромжгүй.
- *Захиргааны шийдвэр гаргах* – Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны акт хэлбэрээр шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзсэн тул сонгох боломжгүй.
- *Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах* гэсэн хувилбарыг сонголоо.

Сонгосон хувилбаруудын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны эерэг, сөрөг тал:

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1. уульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хүүхдийн төлөөх бүтээн байгуулалт, тив дэлхийн тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах хөрөнгө санхүүжилтын эх үүсвэр бүрдэнэ.	Улсын төсвөөс зардал гарахгүй. - Тээврийн хэрэгслийн улсын дугаарын үнэ хаялцуулах дуудлага худалдаанаас олсон орлого; - хүүхдийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн соёл урлаг, спортын тоглолтын хандив; - гадаад улс, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон төслийн санхүүжилт; - хувь хүн, хуулийн этгээдээс өргөсөн,

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар дараах асуудлуудыг шийдвэрлэх боломжтой тул “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг сонгов.

Дөрөв. СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбаруудын үр нөлөөг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 6.2-т заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргасан болно.

4.1. ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүүхдийн эрхийн тухай хуулийн зорилт, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцэд заасан хүүхдийн язгуур эрх эрхийг баталгаатай эдлүүлэхэд чиглэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсныг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн төлөө сан, тусгай сангийн үйл ажиллагааг тогтвортой болгох үүднээс аж

ахуйн нэгж, байгууллагаас хандив, тусламж авах, тээврийн хэрэгслийн сонирхол татсан улсын дугаарын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх зохицуулалтыг тусгаснаар улсын төсөвт учрах дарамт багасгаж, сангийн мөнгөн хуримтлал өсч хүүхдийн төлөөх бүтээн байгуулалтыг бий болгох санхүүжилт бүрдэнэ. Тухайлбал, тээврийн хэрэгслийн сонирхол татсан улсын дугаарын дуудлага худалдааны орлогоос 387,0 саяас 6,0 тэрбум хүртэлх төгрөг Хүүхдийн төлөө санд хуримтлагдах боломжтой байна.

Мөн хүүхдийн төлөө сан, тусгай санд хандив, тусламж өгсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг олон нийтэд сурталчилан таниулснаар тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг үнэлэх, итгэх хэрэглэгчдийн тоо өсөж, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ. Ингэснээр хандив, тусламж өгсөн аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн шууд ач холбогдолтой болно.

Улсын төсвөөс зардал гарахгүйгээр сангийн хөрөнгөөр хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг бий болгож, хүүхдийн хөгжлийн орчин, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд эдийн засагт эерэг үр нөлөөг авчирна.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хүүхдийн төлөө санг сэргээж, сангийн хөрөнгийг хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тив дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан, тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг урамшуулахад зарцуулснаар хүүхэд өсвөр үеийнхний хөгжил, оролцоог дэмжиж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, тэднийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чухал нөлөө үзүүлнэ. Тухайлбал,

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Хүүхдийн төлөө сангийн санхүүжилтээр Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Засгийн газрын 2020 оны 205 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Олон Улсын Хүүхдийн Найрамдал 2 зусланг барьж байгуулахад сангийн хөрөнгийг зарцуулснаар хүүхдийн хөгжих, оролцох эрх хангагдаж, хөгжлийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, улмаар нийгэмд эерэг нөлөө бий болно.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Тав. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна хэмээн тооцоолж байна. Үүнд:

1. Хүүхдийн төлөө сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын эрх зүйн орчин боловсронгуй болж, сангийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, бодитой хэрэгжих боломж бүрдэнэ.

2. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим -ийн хэрэгжилтийг хангаж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийгмийн хариуцлагын

хүрээнд хүүхдийн төлөө төлөө өгсөн хандив, тусламжийн хөрөнгө нэгдсэн зохицуулалтаар хэрэгтэй үйл ажиллагаанд хяналттай зарцуулагдаж, хүүхдийн эрхийн төлөө иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдэхийн зэрэгцээ Хүүхдийн төлөө санд хуримтлал бий болох, улсын төсөвт хүүхдийн чиглэлийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхэд дэмжлэг болно.

3. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12.1.5 дахь “хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, шагнаж урамшуулах журмыг Засгийн газар батална” гэсэн заалтыг хэрэгжүүлэх санхүүжилт шийдвэрлэгдэж, төрөөс хүүхдийн авьяас чадвар, хөгжлийг дэмжих үйл ажиллагаа илүү бодитой болно.

4. Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтууд бий болж, хүүхэд, өсвөр үе залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нэмэгдэж, хүүхдийн хөгжих, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдана.

ХАВСРАЛТ:

Хүснэгт 1.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм √	Үгүй	
	1.1.2 Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй √	
	1.1.3 Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм √	Үгүй	Хүүхдийн эрхийн талаарх олон улсын хэм хэмжээнд нийцүүлж байгаа
	1.2 Оролцоог хангах			
	1.2.1Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм √	Үгүй	
	1.2.2 Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсвэл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм √	Үгүй	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг байхгүй.
	1.3 Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1 Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм √	Үгүй	Хүүхдийн хөгжих, оролцох эрхийг хангах үйлчилгээний орчин, хүртээмж нэмэгдэнэ.
	1.3.2Зохицуулатын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-ээс өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм √	Үгүй	НҮБ-ын ХЭТК, Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжийг хангаж байгаа
	1.3.3Хүний эрхийг зөрчигчдөд	Тийм	Үгүй	√

	хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх			
1. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1 Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм √	Үгүй	
	2.2 Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй √	
2. Эрх агуулагч	3.1 Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм √	Үгүй	
	3.2 Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм √	Үгүй	Хүүхдийн хөгжих эрхийг хангана
	3.3 Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм √	Үгүй	Хүүхдийн хөгжих эрхийг хангана
	3.4 Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгасан эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлагдахгүй)	Тийм √	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, алслагдсан бүс нутгийн хүүхдийн хөгжих эрхийг хангах
3. Үүрэг хүлээгч	4.1 Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм √	Үгүй	
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1 Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм √	Үгүй	
	5.2 Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм √	Үгүй	

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй √	Сөрөг нөлөө үзүүлэхгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй √	
	2.2Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
	2.3 Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
	2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1Зохихуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй √	
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдаан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй √	
	3.4 Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсвэл хориг тавих эсэх	Тийм	Үгүй √	
	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй √	
4. Мэдээлэх	4.1 Хуулийн этгээдэд	Тийм	Үгүй	

үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах гм) бий болгох эсэх		√	
5. Өмчлөх эрх	5.1 Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх, болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
	5.3 Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа, шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм √	Үгүй	
	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм √	Үгүй	
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм √	Үгүй	Хүүхдэд чиглэсэн үйлчилгээнд дотоодын зах зээлийг ашиглах боломж бүрдэнэ
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
	7.4 Хувь хүний/ гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
	8.2 Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	8.3 Жижиг, дунд үйлдвэр,	Тийм	Үгүй	

	эсвэл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		√	
9. Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй √	
	9.3 Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй √	
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм √	Үгүй	Хүүхдийн хөгжлийг дэмжих орчин үйлчилгээний төрөл нэмэгдэх хирээр ажлын байр нэмэгдэнэ гэж үзэж байна. Мөн гэр бүлийн тааламжтай уур амьсгал хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм √	Үгүй	
	10.3 Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй √	
11. Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм √	Үгүй	

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болгох эсэх	Тийм ✓	Үгүй	Хүүхдэд зориулагдсан үйлчилгээ нэмэгдэхэд ажлын байр дагаж нэмэгдэнэ
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	Нөлөө үзүүлэхгүй
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм ✓	Үгүй	Хүүхдэд зориулсан үйлчилгээ нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	Эерэг нөлөөтэй
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	Эерэг нөлөөтэй
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	2.4 Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм ✓	Үгүй	Хүүхдийн хөгжлийн үйлчилгээ, орчны стандартууд бий болно.
	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
3. Нийгмийн тодорхой	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй ✓	Эерэг нөлөөтэй

бүлгийг хамгаалах асуудал	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэсний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй √	Эерэг нөлөөтэй
	3.3 Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Чиг үүргийн хуваарилалтыг хийнэ.
	4.2 Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Чиг үүргийн давхцлыг арилгана
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Эрх, үүрэг, байгууллагын чиг үүргийн хуваарилалтыг хийнэ.
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
5. Нийтийн эрүүл мэнд аюулгүй байдал	5.1 Хувь хүн / нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Гэр бүлийн тааламжтай уур амьсгал эерэг нөлөөтэй.
	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөө, архи, тамхины хэрэглээ) –т нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Гэр бүлийн тааламжтай уур амьсгал амьдралын хэв маягт эерэг нөлөөтэй.
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Гэр бүлийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэг өөрчлөлт гарна.
	6.2 Ажилчдын боловсрол,	Тийм	Үгүй	

	шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		✓	
	6.3 Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтанд хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	Гэр бүлийн боловсролтой болгомноор эерэг нөлөө гарна.
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	6.5 Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	Гэр бүлийн тайван дулаан уур амьсгал хүчирхийллийг багасна.
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		✓	
	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм ✓	Үгүй	Гэр бүлийн дэвшилтэт уламжлалт хадгалагдана.
	8.2 Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсвэл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	8.3 Иргэдийн түүх соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	Эерэг нөлөөтэй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1 Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх / бууруулах эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	2.2 Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	2.3 Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	2.4 Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
3. Ан амьтан, ургамал хамгаалах	3.1 Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	3.2 Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	3.3 Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
4. Усны нөөц	4.1 Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	4.2 Усны бохирдол нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	4.3 Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
5. Хөрсний бохирдол	5.1 Хөрсний бохирдолд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	5.2 Хөрс эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
6. Газрын ашиглалт	6.1 Ашигладаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	6.2 Газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй √	Нөлөө үзүүлэхгүй
	6.3 Экологийн	Тийм	Үгүй	Нөлөө

7. Нөхөн сэргээгдэх / нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	зориулалтаар хамгаалагдсан газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх		✓	үзүүлэхгүй
	7.1 Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм ✓	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй
	7.2 Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй ✓	Нөлөө үзүүлэхгүй

Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дуудлага худалдааны судалгаа¹

№	улсын дугаарын ангилал	Тоо ширхэг	Дээд		Дундаж	
			Нэг бүрийн	Нийт	Нэг бүрийн	Нийт
1	000A	9	5,000,000	45,000,000	3,000,000	27,000,000
2	AAAA	9	5,000,000	45,000,000	3,000,000	27,000,000
3	A000	9	2,000,000	18,000,000	1,000,000	9,000,000
4	0AAA	9	1,000,000	9,000,000	500,000	4,500,000
5	0A00	9	1,000,000	9,000,000	500,000	4,500,000
6	00A0	9	1,000,000	9,000,000	500,000	4,500,000
7	00AA	9	1,000,000	9,000,000	500,000	4,500,000
8	00AB	72	500,000	36,000,000	300,000	21,600,000
9	ABAB	90	500,000	45000000.00	300,000	27,000,000
10	AABV	81	500,000	40,500,000	300,000	24,300,000
11	ABVA	90	300,000	27,000,000	200,000	18,000,000
Нийт дүн		396		292,500,000		171,900,000

№	улсын дугаарын ангилал /орон нутаг/	Тоо ширхэг	Дээд		Дундаж	
			Нэг бүрийн үнэ	Нийт	Нэг бүрийн	Нийт
1	000A	9	1,000,000	9,000,000	500,000	4,500,000
2	AAAA	9	1,000,000	9,000,000	500,000	4,500,000
Нийт дүн		18		18,000,000		9,000,000

Авто тээврийн үндэсний төвөөс хийсэн судалгаагаар Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дуудлага худалдаагаар Улаанбаатар хотын 1 сери бүхий 396 дугаар, орон нутгийн 1 сери бүхий 18 дугаарыг худалдаалж дунджаар 300 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр тооцсон байна.

¹ Авто тээврийн үндэсний төв